




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ  
**4368 СЯА АМ.ДОЛЛАР**



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ  
**11.6%**



НИЙТ ХАДГАЛАМЖ  
**18.2 ИХ НАЯД ТӨГ**



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР  
**32.1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР**



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ  
**1006 ТЭРБУМ ТӨГ**



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ  
**6%**

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: **5.1%**,  
Инфляци: 2021 онд: **8.2%**,  
Урсгал тэнцэл: 2021 онд: **-8.3%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: **6%**  
Инфляци: 2021 онд: **5.5%**,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: **-13.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 1-р сарын байдлаар 118.5 тэрбум төгрөгийн ашигтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 6 хувиар буурсан бол, зарлага 22.3 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 118.5 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 276.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 0.27 төгрөгөөр буурсан байна.**

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 105.4 төгрөг буюу 3.8 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.27 төгрөг буюу 0.01 хувиар нэмэгдэж, өмнөх улирлаас 0.13 хувиар буурч 2849.82 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 4.3 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 4 хувиар, оны эхнээс 4 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 0.14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




**Инфляцийн түвшин 2.4%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 1-р сарын байдлаар өмнөх сараас 1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, оны эхнээс 1 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 2.4 хувь гарсны 2.2 нэгж буюу 91.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.




**Гадаад худалдааны тэнцэл 181.1 сая.ам долларын ашигтай гарав.**

2021 оны нэгдүгээр сард нийт барааны эргэлт 1098.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 19 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 39 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 3.06 хувиар буурч гадаад худалдааны тэнцэл 181.1 сая ам.долларын ашигтай гарав.



## 1-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ДНБ 2020 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 279.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 41,944 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 5.3 хувиар буурав. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 онд 7.2 хувь, 2019 онд 5.2 хувийн өсөлттэй гарч байсан ч 2020 оны эхний улиралд 10.7 хувь, эхний хагас жилд 9.7 хувь, эхний 9 сард 7.3 хувь, жилийн дүнгээр 5.3 хувийн бууралттай гарлаа. Статистикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12,535 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт -5.3% болов.

## САРЫН ОНЦЛОХ

**ИРГЭДЭД 99,5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ШИНЭЭР ОЛГОВ.**

- Монголбанк болон арилжааны банкны санхүүжилтийн хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 1 дүгээр сарын 25-ны хооронд банкууд нийт 99,5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 1362 өрхөд олгожээ. Түүнчлэн коронавируст цар тахлын хүндрэлтэй холбоотой банкууд орон сууцны ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс хүлээн авч шийдвэрлэв. Нэгдүгээр сарын 22-ны байдлаар нийт 53,180 зээлдэгч хүсэлт гаргаснаас 52,384 хүсэлтийг буюу 99 орчим хувийг шийдвэрлэж, зээлийн эргэн төлөлтийг хойшлууллаа.

**ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ 17 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЭВ.**

- Өнгөрсөн оны эцсийн байдлаар зээлийн үлдэгдэл 17 их наяд төгрөгт хүрэв. Зээлийн үлдэгдлийн 8.5 их наяд төгрөг нь иргэдийн, 7.9 их наяд төгрөг нь байгууллагын зээл эзэлж байна. Нийт зээлийн 9.3 хувь нь гадаад валютаар олгосон бөгөөд зээлийн 11.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.4 хувь нь чанаргүй зээл байна. Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 8.4, гадаад валютынх 3.7 хувь байгаа бол шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү төгрөгийн хувьд 14.8, гадаад валютынх 9.8 хувьтай байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 1-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 1-р сар 2020 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)